



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 5/4

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч Д.Оюунтуяа өөр ажилд шилжин ажиллах болсон тул үүрэгт ажлаас нь 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: С.Энхтоогоо

-Төсвийн зарлага хариуцсан
мэргэжилтэн

Гишүүдэд:

Ж.Ган-очир

-Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн

Н.Шинэбаяр

-ЗДТГ-ын нягтлан бодогч

Т.Баяртуяа

-ЗДТГ-ын аж ахуйн нярав

Т.Бямбадулам

-ЗДТГ-ын Архив, бичиг хэргийн
эрхлэгчийн албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

3. Д.Оюунтуяатай зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусгахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА